



ХЭНГИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 4/18

Модот

Ажлын хэсэг томилох тухай
(Угтах хаалга шинэчлэх, засварлах)

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн, 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, 50 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа сумын угтах хаалга шинэчлэх, засварлах ажлыг гүйцэтгэх үйл ажиллагаанд хяналт тавьж, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч Г.Болор-Эрдэнэ – Санхүү албаны дарга

Нарийн бичгийн дарга Д.Өсөхгэрэл – Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний хяналтын улсын байцаагч

Гишүүд

С.Ган-Очир

- Нярав

Э.Навчаа

- Соёлын төвийн дарга

О.Батбаяр

- Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн

2. Дээрх ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, байгуулсан гэрээний дагуу гэрээг дүгнэх, хүлээн авах акт үйлдэх, гүйцэтгэлийн тайланг гүйцэтгэгчээс гаргуулж авахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Болор-Эрдэнэ) –д үүрэг болгосугай.

ДАРГА

У.ИЧИНХОРЛОО